

**Б.МӨНХБААТАР**

Шүүхийн шийдвэр  
гүйцэтгэлийн  
сургуулийн Нийгмийн  
ажлын тэнхимийн  
багш, ахлах дэслэгч

### АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛ ЗҮЙН БЭЛТГЭЛИЙН ОЙЛГОЛТ

Сэтгэл зүйн бэлтгэл нь маш олон зүйлээс хамааралтай, олон хэсэг бүхий нарийн төвөгтэй процесс юм. Эдгээр хүчин зүйл бүрдэл хэсгүүдийг оновчтой тодорхойлсноор сэтгэл зүйн бэлтгэл гэдэг утга агуулгын үндэс болно гэж үзлээ. Өөрөөр хэлбэл хүний сэтгэхүйн үйл ажиллагааны талаар түүний танин мэдэх үйл ажиллагаа, харилцан хамаарлын талаар тодорхойлсноороо илүү ойлгомжтой болох юм. Түүгээр ч зогсохгүй бид өөрсдийнхөө болоод хэн нэгнийхээ аливаад хандах хандлагыг өөрчилж чадах байх.

Мөн амьдрахын хэрээр ч бидний мэдлэг их бага хэмжээгээр нэмэгддэг. Сэтгэцийн буюу мэдрэлийн системийн үйл ажиллагаа, хүч нь бидэнд төрөлхөөс бий болдог бөгөөд харин сэтгэцийн үйл ажиллагааны онцлог шинжүүдийн талаар тодорхой ойлголтыг бий болгохыг зорьлоо.

Ой гэдэг нь хамгийн ерөнхий утгаараа амьдралын туршлага бий болох, түүнийгээ хадгалан аливжуулах, сэргээн санах чадвар байдаг. Зөн билэгийн олон янзын хэлбэрүүд болон хүний зан үйлийн төрөлхийн ба амьдралын явцад бий болдог оньсууд нь удамшлын замаар болон хувийн

амьдралын туршлагын дүнд хэлбэржин бүрэлдэж, өвлөгддөг хэмээн үздэг. Энэ бүх туршлагыг байнга шинэчилж, тодорхой нөхцөл байдалд нийцүүлэн өргөтгөн хөгжүүлэхгүйгээр амьд биетүүд өөрсдөө түргэн өөрчлөгдөж байгаа гадаад орчин, амьдралын хөгжил хөдөлгөөний хэмнэлд дасан зохицох боломжгүй юм.<sup>169</sup> Ой тогтоолт нь хүн төрлөхтний /өнгөрсөн үе/ генийн ба бусад хэлбэрийн ой тогтоолтын ул мөр хэлбэрээр үлдэж хоцорсон байдаг бол ирээдүй нь мөрөөдөл, хүсэл тэмүүлэл дүрслэн бодохуйн хэлбэрээр гол төлөв гаднаа илэрдэг. Тэдгээрийг хүн өөрийн зоригийн тусламжтайгаар сэргээн санаж, амьдруулж, хооронд нь холбох боломжтой байдаг. Ой бол ямар нэг юмс, үзэгдлийг оюун ухаандаа тогтоон хадгалах ба өнгөрсөн амьдралын туршлагад тохиолдсон юмс, үзэгдлийг хожим нь сэргээн санах чадвар /ажиллагаа/ юм.<sup>170</sup> Өөрөөр хэлбэл ойн тусламжтайгаар хүн бүр өнгөрснөө санаж одоогийн байдлаа тодорхойлон ирээдүйгээ урьдчилан харж, өөрийн болон бусдын туршлагаас бүхий л амьдралынхаа туршид мэдлэг, туршлагыг эзэмшин хуримтлуулж хадгалаж байдаг онцлогтой гэсэн үг юм.

Бид дүрслэн бодохуйн тусламжтайгаар өөрсдийн болон бусдын сэтгэц физиологийн олон янзын төлөв байдлыг удирдан чиглүүлэх, үйл ажиллагааныхаа сэтгэл зүйн бэлтгэл, давуу байдлыг илүү сайн хангах боломжтой болдог.

<sup>169</sup> Д.Доржжав Сэтгэл зүйд өөрөө суралцах нь УБ., 2005., 300-р тал

<sup>170</sup> С.Жанцан Хууль зүйн сэтгэл судлал УБ., 2001, 87-р тал

Дүрслэн бодохуй нөхцөл байдлыг ухаарах, баримжаалах болон тулгамдсан зорилтыг бодит үйлдлээр заавал дамжуулахгүйгээр бодит дүрслэлийн сэтгэхүйн үндэс болдог.

Энэ утгаараа дүрслэн бодохуй нь хүний практик үйлдэл ямар нэг хүндрэл бэрхшээлтэй учрах юмуу элдэв үйлдэл гүйцэтгэх боломжгүй, эсвэл тэр бүхнээс зайлсхийх шаардлагатай нөхцөлд хүний амьдралыг гэрэл гэгээтэй, хэвийн байлгах, ирээдүйдээ итгэх боломжийг бүрдүүлж байдаг гэж ойлгож болно. Дүрслэн бодохуй нь хүний сэтгэцийн үзэгдлүүд дотроос хамгийн хийсвэр, содон шинжтэй, алсыг харах шинж чанар нь гойд тод илэрдэг үйл явц юм.<sup>171</sup>

Хүний амьдрал үйл ажиллагааны явцад дүрслэн бодохуй хэд хэдэн тусгай чиг үүрэг гүйцэтгэдэг. Тэдгээрийн анхдагч нь бодит байдлыг дүрд хувирган төсөөлж, аливаа нэг зорилгыг шийдэх үедээ заавал дүрслэхүйг ашигладаг явдал юм. Дүрслэн бодохуйн хоёрдогч үүрэг нь сэтгэлийн хөдөлгөөнийг зохицуулах байдлаар илэрдэг бөгөөд хүн өөрийн дүрслэн бодохуйн тусламжтайгаар олон янзын хэрэгцээнийхээ зарим хэсгийг нь эхэлж хангах, тэр үед үүсч бий болдог ачаалалыг арилгах боломжтой болдог. Дүрслэн бодохуйн гуравдагч үндсэн үүрэг нь хүний танин мэдэхүй үйл явц ба сэтгэл санааны байдал, сэтгэл хөдлөл зэргийг зориудаар зохицуулахад оролцох, хооронд нь уялдуулах байдлаар

илэрдэг. Зориудаар зохион байгуулалттай бий болгож байгаа дүр, дүрслэлийн тусламжтайгаар хүн нэн чухал үйл явдал, юмс үзэгдэлрүү сайн дураараа анхаарлаа хандуулах боломж нээгддэг. Хүний амьдралд дүрслэн бодохуйн гүйцэтгэх дөрөв дахь үндсэн үүрэг нь үйлдийн дотоод төлөвлөлт бий болгох хэлбэрээр хэрэгжинэ. Энэ нь хувь хүн тэдгээр дүрслэлийг ашиглаж оюун санаандаа шаардагдах үйлдлүүдийг эрэмбэ дараалалтай хийж гүйцэтгэх чадвартай болох хэрэгтэй гэсэн үг. Мөн дүрслэн бодохуйн үндсэн үүргүүдийн тав дахь үндсэн үүрэг нь төлөвлөх буюу үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулах, түүнийхээ хэрэгжилтийг урьдчилан харах байдлаар илэрдэг.<sup>172</sup>

Энгийн үгээр хэлбэл хүн ямарваа нэг асуудалд хандах, шийдвэр гаргах үед тухайн үйлийн бодит мэдээлэл, бүхий л онцлог шинж болон өөрийн амьдралын дадлага туршлага "Ой тогтоолт", "Дүрслэн бодохуй"-н үндсэн дээр ямар нэг төсөөллийг бий болгодог гэсэн үг юм.

Хүн ямар нэг ажилд орох, тухайн ажилдаа амжилт гаргах, даалгавар гүйцэтгэх гээд ердийн үйл ажиллагаанаас илүү хүчин зүтгэл гаргах үед бэлэн байх байдал буюу сэтгэл зүйн бэлтгэл ихээхэн нөлөө үзүүлдэг. Энэ нь хүн ямарваа нэг ажил үүргийг хийж гүйцэтгэх, хийж бүтээх үйлд зайлшгүй нэг төрлийн айдас, түгшүүрийг мэдэрч байдагтай холбоотой юм.

Тэгэхээр түгшүүр гэдэг нь танин мэдэхүйн, бие мах бодийн,

<sup>171</sup> Сэтгэл зүйд өөрөө суралцах нь УБ. 2005он 346-р тал  
О.Мягмар – Сэтгэл судлал УБ 2006 он

<sup>172</sup> Сэтгэл зүйд өөрөө суралцах нь УБ. 2005он 341-р тал

сэтгэл хөдлөлийн болон ааш авирын бүрэлдэхүүн хэсгүүдээр тодорхойлогддог сэтгэл зүйн болон физиологийн нэгэн байдал юм<sup>173</sup>. Эдгээр бүрэлдэхүүн хэсгүүд нь нэгдэж тайван бус байдал, айдас, зовнил зэрэгтэй хамааралтай таагүй мэдрэмжийг төрүүлдэг. Түгшүүр нь ямар нэгэн бодит тодорхой хүчин зүйлгүйгээр буй болдог сэтгэлийн нэг байдал юм. Өөр нэгэн үзлээр түгшүүр нь удахгүй болох сөрөг зүйлсийг даван туулахад биеэ бэлтгэж буй ирээдүйг чиглэсэн сэтгэцийн өөрчлөлт юм. Өөрөөр хэлбэл айдас нь одоогийн аюулын улмаас төрдөг байхад сэтгэлийн түгшүүр нь ирээдүйд болзошгүй аюулын улмаас төрдөг сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл юм. Түгшүүр нь стресст үзүүлж буй хэвийн хариу үйлдэл гэж ойлгож болдог. *Түгшсэн түвшин өндөр байх тусам хийж буй зан үйл нь тухайн нөхцөлд зохицохгүй байдаг.*

Бид ямарваа нэг эрсдлийн нөхцөлд өөртөө итгэлтэй байх, нөхцөл байдалд хурдан дасан зохицох, хариу үйлдэл үзүүлэх нь хувь хүн сэтгэл зүйн хувьд бэлтгэгдсэн хэлбэр гэж тодорхойлж ойлгож болно.

Хүн өөрийн гэсэн орон зайд дасан зохицсон байдаг. Энэ орчныг солиход хүн биеэ барьж, сурах чадвар нь өөрчлөгддөг. Энэхүү зүй тогтол нь сурсан зүйлээ хэрэгжүүлэх явцтай холбоотой илрэх явдал бий. Мөн бид орчны өөрчлөлтөд тэр бүр бэлэн биш байж болох ч хуучин төрлийн хариу үйлдлээ орхих, шинийг олж авах

замаар хүмүүс шинэ орчинд төвөггүй хурдан дасан зохицож чаддаг.<sup>174</sup> Тухайлбал тодорхой сургалтын орчинд олж авсан мэдлэг, чадвар, дадал нь бодит үйл ажиллагааны орчинд өөрчилөгддөг гэсэн үг юм.

Бие хүний шинж тэмдэг олон болохоор сэтгэцийн хөгжлийг амьдралын явцад үүсэн хөгждөг шинж тэмдгүүд, тэдгээрийн үүсэл, өөрчлөн хувиргалт, тогтворжилтын байдлыг биологийн бус өвөрмөц зүй тогтолд захирагддаг хэмээн үздэг. Нийгмийн даган сургалтын онолын хувьд сэтгэцийн хөгжлийн явцыг бие хүн хоорондын харилцааны үед хүмүүс өөр хоорондоо харилцан үйлчлэх, хамтран ажиллах арга барил хэв загвар бүрэлдэж, тэр нь эдгээр хөгжлийн хүчин зүйл болж хувирах талаас нь тайлбарладаг. Нөхцөл байдлын талаар байгаа мэдээлэл дээр үнэслэн авч болох аюулгүйн арга хэмжээ, цаашид гарч болзошгүй өрнөлийн талаар төсөөлөл бий болгох явдал юм.

Бид ямар нэг байдлаар өвчинд өртөмтгий болоод ирмэгц биеийн эсэргүүцэл суларлаа, дархлаа муу байна гэж ярьдаг. Тэгвэл хүний аливаа зүйлд амжилт гаргах, сэтгэл санаа амар амгалан байх, стресс, неврозод өртөхгүй байх зэрэгт "сэтгэл зүйн бэлтгэл" нь ихээхэн чухал үүрэгтэй байдаг.

#### Санал:

Нийт бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн бэлтгэлийг онцгойлон анхаарч, түүний сургалт, бэлтгэл, шалгуурыг судлан тодорхойлж бодитойгоор

<sup>173</sup> О.Мягмар – Бие хүний онол УБ 2001он

Д.Санжжав Л.Жамц - Ерөнхий сэтгэл судлал УБ 2007он

<sup>174</sup> Science and Human Behavior. N.Y., Programm Press. 1972. P. 78-83

хэрэгжүүлэх нь үйл ажиллагаа ба сургалтын салшгүй хэсэг бөгөөд болзошгүй эрсдэлд сөрөг няцаалт өгөх чадварыг баталгаажуулах чухал хүчин зүйл, итгэл үнэмшил болж өгнө.

Хэрхэн яаж өөрчлөгдөх өсөх үү, буурах уу гэдэг нь бэлтгэл сургуулилтын чанараас хамаарах нь зайлшгүй, бодит байдалд ойртсон төрөл бүрийн орчинг бүрдүүлсэн нөхцөлд бэлтгэх нь жинхэнэ үйл ажиллагаанд сандарч балмагдах нь бага байхаас гадна, хүртэхүй, сэтгэхүй, анхаарал, ойн оператив шинжид илрэх сөрөг үзэгдэл бага байна.

Сэтгэл зүйн бэлтгэл нь түүний хувийн бэлтгэлээр хязгаарлахгүй хамт олны нөлөөлөл, төлөвшилт, хоорондын харьцаа, дулаан уур амьсгал зэрэг нь сэтгэл зүй, бие бялдарын хөгжлийн түвшинг ихээхэн чанаржуулдаг. Нэгдэл нягтралтай эвсэг хамт олны доторх бэлтгэл сулхан гишүүн ч өөрийгөө итгэлтэй үнэлж, учирсан бэрхшээлийг зоримгоор давж туулдаг нь олонтаа. Иймд нөхцөл байдалтай уялдуулан хамт олны сэтгэл зүйн таатай уур амьсгалыг төлөвшүүлэх, тэдгээрийг удирдах нь чухал юм.

\* \* \*

## О.БАЯРЖАРГАЛ



Шүүхийн шийдвэр  
гүйцэтгэлийн  
сургуулийн Нийгмийн  
ажлын тэнхимийн  
багш, ахлах дэслэгч

### СУЛЛАГДАХ ЯЛТАНД ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН АЖЛЫН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ял, түүний зорилгын талаарх үзэл баримтлал, хандлага: Германы эрүүгийн эрх зүйн орчин үеийн буюу өнөөгийн онолд ялыг гэмт үйлдэл хийсэн гэм буруутай этгээдийн эрх зүйн үр дагавар гэж тодорхойлсон байдаг. Тодруулбал, хуучны уламжлалт ойлголтоор ялын мөн чанарыг “хариу авах” эсвэл айлгах, эмээлгэх гэсэн агуулгаар авч үзэхээс аль болох татгалзаж харин хор уршиг учруулна гэдэг нь шударга ёс биш хэмээн тунхагладаг хуульчдын номлол хүчтэй давамгайлдаг.

Тиймээс ч Германы Эрүүгийн хуулийг Европын улсууд дотор хамгийн “зөөлөн” хуульд оруулдаг нь ялын бодлоготой нь шууд холбон тайлбарлаж болно. Ялын мөн чанарыг танин мэдэхийн тулд түүний зорилгыг тодорхойлох ёстой. Уламжлалт номлол сургаалд ял нь зорилготойгоо хэрхэн уялдаж байгаагаар түүний ойлголтыг тодорхойлж байсан.

Ялангуяа 19-р зууны Германы эрүүгийн эрх зүйн номлолд ял ба түүний зорилгын харилцан хамаарлыг судлан ялын туйлын ба харьцангуй онолыг бий болгосон. Туйлын онолын үүднээс авч үзвэл ялын гол зорилго нь хариу авах аргаар тодорхойлогдоно